

**Монгол хэлний энгийн өгүүлбэр,
түүний бүтэц, хэвшинж**

Өгүүлбэр гэж юу вэ?


Хэлний талаас

- ▶ Хам бүтэц мөн;
- ▶ Өгүүлбэр=Үг+Нөхцөл;
- ▶ Өгүүлбэр=Юм+Хөдөлгөөн;


Хэлэхийн талаас

- ▶ Цуваа бүтэц мөн;
- ▶ Хэлэх аялга, өгүүлэх зорилго: асуух, хүүрнэх, захирах, анхааруулах;

Өгүүлбэр бол үгсийг хэлзүйн холбоосоор холбосон, хэлний талаас тогтвортой хам, хэлэхүйн талаас тогтворгүй цуваа бүтэцтэй, мэдэгдэхүүний талаас хэлний нэрлэх шинжийг агуулсан, мэдэхүүний талаас хэлний харилцах, мэдээлэх үүргийг тус тус хангаж байдаг хэлний төгс нийлмэл дохио юм.



Монгол хэлний энгийн өгүүлбэрийг ангилах нь



Бүтэц бус өгүүлбэр, түүний төрлүүд

- ▶ Сэтгэл хөдлөл, мэдрэхүйн шинжтэй аялга үгэнд тулгуурлан бүтсэн; Мэдрэхүй ба сэтгэлийн хөдөлгөөний өнгө аясыг тусгасан;
- ▶ Нэг талаас харилцах, мэдээлэх түвшний, нөгөө талаас хэлэхүйн өгүүлбэрийг хэлнэ;
- ▶ Цааш үл задрах;
- ▶ Үндэстний өвөрмөц онцлогийг тусгасан;
- ▶ Өгүүлэгчийн тухайн юмс үзэгдэлд хандах хандлагыг тусгасан;



Жинхэнэ аялга өгүүлбэрийг ангилах нь

ЖИНХЭНЭ АЯЛГА

Сэтгэлийн хөдөлгөөнийг
илэрхийсэн

*Уухай, Ура, Хөөрхий,
ха ха... Дан ба давхар
бүтэцтэй*

Мэдрэхүйн шинж
байдлыг илэрхийлсэн

Ёо ёо, тий тий, пөөх

Хүн ба амьтныг дуудах
утгатай

Хүүе, Хаая, Хөж, Чаа,

Гол төлөв ярианы эхлэл
болдог, аялга өгүүлбэр

За...

Жинхэнэ бус аялга үг-өгүүлбэр

- ▶ БҮТЭЦ: Бүтцийн хувьд өгүүлбэрийн тийм, ийм гишүүн гэж задрах зүйлгүй;
- ▶ Тухайн өгүүлбэрийн цөм бүрэлдүүлэгч ба дагуулагч бүрэлдүүлэгчийн аль алийг нь задрахгүй болтол нь “хураасан”;
- ▶ Янз бүрийн нөхцөлгүй үгээс бүтэж, харилцааны үүргийг хангаж байдаг:

ТИЙМ

ҮГҮЙ

МАГАДГҮЙ

МӨН

БИШ

АШГҮЙ



Бүтэц өгүүлбэр, түүний төрлүүд

Үг нөхцөлийн хослолыг дамжиж бүтсэн, нэрийн ба үйлийн бүрэлдэхүүнтэй өгүүлбэр юм

Агуулга, хэлбэртэй

Бүрдэл хэсэгтэй

Дотоод, гадаад
талтай

Юм-Хөдөлгөөн-Харьцаа

Хэл, хэлэхийн
талаас үүрэгтэй

Нэрлэх-Мэдээлэх-
Харилцах



Бүтэц өгүүлбэрийг ангилах нь



Хоёр бүрэлдэхүүнт өгүүлбэр



ХОЁР БҮРЭЛДЭХҮҮНТ ӨГҮҮЛБЭРИЙГ

Логик

- Субъект + предикат

Хэлзүй

- Өгүүлэгдэхүүн+өгүүлэхүүн

Үг+нөх=Ө

- N (Нэр.т.я) + V (Үйлийн хамаат.нөх)

Утга

- Үйлдэгч, үйл хүлээгч+Үйл, байдал, явц, болц

Хэлэхүйн
гишүүлбэр

- Дэвсвэр ба Онцолбор
-



ХОЁР БҮРЭЛДЭХҮҮНТ ӨГҮҮЛБЭРИЙГ

Хураангуй хоёр бүрэлдэхүүнт

- ▶ Онгоц хөөрөв - ҮЙЛ
- ▶ Хүүхэд инээнэ - БАЙДАЛ
- ▶ Цай буцлав - ЯВЦ
- ▶ Цаас шатав – БОЛЦ

- ▶ ӨГҮҮЛЭГДЭХҮҮН
- ▶ ӨГҮҮЛЭХҮҮН

Дэлгэрэнгүй хоёр бүрэлдэхүүнт

- ▶ Орон нутгийн онгоц яг цагтаа хөөрөв;
- ▶ Бага ангийн хүүхдүүд чанга чанга инээлдэнэ
- ▶ Өглөөний цай гал дээр буцалж байлаа
- ▶ Зургийн дэвтрийн цаас лааны галд шатав
- ▶ **ӨГҮҮЛЭГДЭХҮҮНИЙ БҮЛЭГ**
- ▶ **ӨГҮҮЛЭХҮҮНИЙ БҮЛЭГ**



Хураангуй өгүүлбэр

- ▶ Өгүүлбэрийн дэлгэрүүлэгч гишүүдийг оролцуулаагүй;
- ▶ Зөвхөн гол гишүүдээс бүтсэн энгийн өгүүлбэрийг хэлнэ;

Өндөр

уулын

бэлд

чулуун

хороотой

бууцан

дээр

нэгэн

хот

айл

харагдана



Дэлгэрэнгүй өгүүлбэр

- ▶ Хураангуй өгүүлбэрийг дэд гишүүдээр нэмэн дэлгэрүүлсэн;
- ▶ Хэлэхэд: Хөдлөнгө, олон хувилбартай
Өгүүлэгдэхүүн өгүүлэхүүнийхээ дэлгэрсэн байдлаар ялгаатай;

Өндөр

уулын

бэлд

чулуун

хороотой

бууцан

дээр

нэгэн


хот

айл

харагдана



Нэг бүрэлдэхүүнт өгүүлбэр



- ▶ Хоёр бүрэлдэхүүнт өгүүлбэрийн бааз дээр үүсдэг;
- ▶ Гүн бүтцээрээ 2 бүрэлдэхүүнт, өнгөн бүтцээрээ 1 бүрэлдэхүүнт байдаг;
- ▶ Ганц гол гишүүний бүлгээр илэрсэн байдаг;



Бүтцийн ерөнхий шинж нь:

Өгүүлэхүүний бүлгээр

- Эрлийг сургаар, эрдмийг хичээлээр;
- Ачийг бачаар, тусыг усаар

Өгүүлэгдэхүүний бүлгээр

- Ашдын бэлгээс амны бэлгэ
- Арьсанд боодолтой арван хоёр чөмөг

Өгүүлэгдэхүүн, өгүүлэхүүний бүлгээр

- бороошив
- Зунд муухай хүнгүй, зудад сайхан амьтангүй



Бүрэн бус өгүүлбэр

► Харилцан ярианд элбэг тохиолдоно:

-Чи хичээлдээ явж байгаа юу?
-Танай хичээл өнөөдөр хэдэн
цагт дуусах вэ?
-Багш чинь гэрийн даалгавар
өгсөн үү?

-(Бу) Явж байгаа
-13.30-д
-Өгсөн

ТОДОРХОЙЛОЛТ

хэлзүйн хувьд байвал зохих зарим гишүүдийг
хурааж, орхиж, нэрлээгүй боловч, хам сэдвээс
нь сэргээн ойлгож болох, мэдээллийн талаасаа
бүрэн өгүүлбэртэйгээ дүйх өгүүлбэрийг **БҮРЭН
БУС ӨГҮҮЛБЭР** гэнэ

БҮС ӨГҮҮЛБЭР гэнэ

БҮС ӨГҮҮЛБЭР гэнэ

Энгийн өгүүлбэрийг өгүүлэх зорилго, аялгын байдлаар ангилах

► ХАРИЛЦАН ЯРИАНД өгүүлбэрийн:



Зэрэг талыг нь харгалзан:

батлах

үгүйсгэх

асуух

Анхааруулах...

Мэдэхүүний талтай холбоотой

Хүүрнэх өгүүлбэр

- ▶ Тоогоороо хамгийн олон;
- ▶ Батлах ба үгүйсгэх зорилготой, үнэн ба худал мэдээллийг агуулсан;
- ▶ Тоочиж нэрлэх, дүрслэн үзүүлэх, хүүрнэх байдлаар хэлсэн өгүүлбэр;
- ▶ Аялга нь тэгш байдаг; Онцолбороос шалтгаалж хэлзүйн гишүүд нь харьцангуй хөдлөнгө байдаг:

Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн улирал ороо бусгаа,
элстэй шанд, буттай цайдмыг дагаж, хааяа нэг хар гэрээс утаа
суунаглана



Асуух өгүүлбэр

- Өгүүлэгч этгээдээс мэдэхгүй, эсвэл тодорхойгүй байгаа зүйлийн талаар лавлан мэдэх зорилгоор хэлсэн асуух мэдээлэл агуулсан өгүүлбэр;

Жинхэнэ асуух

- Хариу шаардана
- *Юу хийх вэ? Хэдэд тарах вэ?...*

Яруу асуух

- Хариу шаардахгүй
- *Од чиний тэндээс энэ дэлхий ямар өнгөтэй харагднам бэ?...*

Таамаглан асуух

- Хариу шаардахгүй, бага зэрэг таамаглах утгатай
- *Чи маргааш ирнэ биз дээ?*

Асуун анхааруулах

- *Чи надтай явах уу үгүй юу? Хурдан босохгүй юу?*



Захирах өгүүлбэр

- ▶ Тухайн үйлийг гүйцэтгүүлэхийн тулд өгүүлэгчийн **захирах, хүсэх, тушаах, гуйх, хүсэх, шаардах, даалгах, ерөөх...** Зэрэг хүсэл шаардлагыг илэрхийлсэн баймж утгатай өгүүлбэр;

аялгаар

☐

☐ *Алив бос, намайг дагаад яв*

☐ *Битгий уйл охин минь*

☐ *Намайг дагаад хийгээрэй*

нөхцөлөөр

☐

☐ *-я, -е, -ё, -сугай2,*

☐ *-Ø,-аарай, -аач, -гтун, -уузай*

☐ *-г, -тугай2, -аасай*



Анхааруулах өгүүлбэр

► Анхааруулах аялга бүхий өгүүлбэр;

аялгаар

- Оюутнууд аа!

Эцсийн үгийн
эгшгийг сунжруулах

- Ойлгосоон

Аялга үг, хандсан үг,
сул үг

- Болохгүй шүү, Хүүе...

Төлөөний үг нэмэх

- Чи битгий мартаарай хүү минь



Өгүүлбэрийн хувиргал

Гишүүдийн
байрыг
хөдөлгөх

- Би явлаа баяртай, битгий намайг дуудаарай
- Битгий намайг дуудаарай, би явлаа

Гишүүн нэмэх

- Бороошив
- Бороо оров
- Ширүүн бороо оров
- Хаврын анхны бороо ширүүн оров

Хураах

- Би ОУУБИС-ийн СХО-ийн 1-р дамжааны оюутан
- Би оюутан



Аль нэг гишүүнийг
өөр үг хэллэгээр
сольж орлуулах

- Эрт урьд цагт эмгэн өвгөн хоёр аж төрөн суудаг байжээ
- Тэр хоёр ганц хүүтэй юмсанжээ

хураах

- Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би
- Би эзэгнэн төрсөн
- Би Төрсөн

Идэвхтэй үг
хэллэгийг идэвхгүй
үг хэллэгээр солих

- Дүү аяга хагалав
- Аяга хагарав



НӨ~Угсарсан НӨ
болгох

- Мал турсан нь тэжээл ус дутсанных
- Тэжээл, ус дутсанаас мал турав

Харь.тодот.
~ хамаатуулах
нөхцөл

- Миний аав адуучин хүн
- Аав минь адуучин

тонгоргох

- Худалч хүний нээрээ олон
- Нээрээ олон нь худалч



Тодосгогч
гишүүнийг давтах

- Эх орон минь есөн эрдэнийн билээ
- Эх орон та минь есөн эрдэнийн билээ

Хандсан үг
оруулах

- Би уначихлаа
- Ааваа, би уначихлаа

Баймж утгатай
үгээр хувиргах

- Бүгдээрээ маргааш цагтаа уулзана ш дээ
- Бүгдээ маргааш цагтаа уулзана биз дээ

Үгийн утга
салаалснаас

- Ам>уутны ам>Ёлын ам>ам хуурайгүй
-



ЭНГИЙН БА НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭРИЙН ЗАВСРЫН БҮТЭЦ

- ҮЙЛИЙН НЭГ ЭЗЭНТЭЙ, ОЛОН ӨГҮҮЛЭХҮҮНТЭЙ
ӨГҮҮЛБЭР:

Дүү минь

өглөө

босоод

цайгаа

ууж,

хувцсаа

өмсөөд

цэцэрлэгтээ

явав

ӨГҮҮЛЭХҮҮНИЙ
ТООГООР ЗАДАРНА

Дүү минь

өглөө

босов

Дүү минь

цайгаа

уув

Дүү минь

хувцсаа

өмсөв...

-
- **ҮЙЛИЙН ОЛОН ЭЗЭНТЭЙ, НЭГ ӨГҮҮЛЭХҮҮНТЭЙ
ӨГҮҮЛБЭР:**

Вандан

Дуламсүрэн

нар

дуулав

Вандан

дуулав

Дуламсүрэн

дуулав

**ӨГҮҮЛЭГДЭХҮҮНИЙ
ТООГООР ЗАДАРНА**



НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭР



Хэв шинжээр нь

Зэрэгцсэн

Харилцан
зэрэгцсэн

Угсарсан



Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

Энгийн өгүүлбэр + Энгийн өгүүлбэр

- ▶ Бүтэц өгүүлбэр+бүтэц өгүүлбэр: **Бороо арилж, тэнгэр онгойв**
- ▶ Бүтэц бус өгүүлбэр+бүтэц өгүүлбэр: **Хөөрхий, тэр минь санаж байгаа даа...**

Зэрэгцүүлэх холбоонд суурилна:

- ▶ Зэрэгцүүлэн холбох үгс: **ба, буюу, бөгөөд, болон, болоод, агаад, авч, хийгээд...**
- ▶ Зэрэгцүүлэн холбох нөхцөл: **-ж, -ч, -аад, -н, -саар...**
- ▶ **... Хүрэн азарга тун холоос цойлон гарч ирээд түрүүллээ шүү**



**Захирагдахгүй, гишүүн ба
гол өгүүлбэрт хуваагдахгүй**

- ▶ *Галдан жонон, Мөнх-Очир та хоёр нас ахиж, юм үзэж, нүд тайллаа даа (Д.Н);*
- ▶ *Хөл нь дөрөөнд, гар нь ганзганд...*

**Хэлэхийн нэг цуваанд
байрладаг**

- ▶ *Нэг дов толгой дээр гараад, дурангаа бариад, суучихдаг... (МШӨ)*
- ▶ Учир шалтгаан, орон, цагийн хамааралгүй учир сольж байрлуулж болдог:



**Бүрэлдэхүүний хувьд дараах
4 хэв маяг зонхилж байна:**

- ▶ **2+2: Хүүхдүүд дуулж,
бид хөгжимдөв;**
- ▶ **1+1: яа яа жимбүүхэй,
яс махгүй жимбүүхэй**
- ▶ **2+1: тэнгэрийн
хаяанаас цааш
газаргүй...**
- ▶ **1+2: Их хүйтэрч,
өвөлжилт хүндэрч
байна**

**Дундын нэг ерөнхий
гишүүнтэй:**

- ▶ **Сонгогчдын олонх нь
өвсөр насных, цөөн хувь
нь ахимаг насных
байна.**



Холбоосгүй зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

Аялгаар холбогдсон:

- ▶ Хөдөөгийн байдал
шалдар булдар, цагийн
улирал ороо бусгаа...
- ▶ Бороо ганц нэг дусах нь
сайхан, Борог өвс норсон
байх нь сайхан



Холбоост зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

*ба, буюу, бөгөөд, болон,
боловч, болоод, агаад, авч, хийгээд...*

БА

Өгүүлбэрийн хэсгүүдийг эсрэгцүүлэн холбоход түрүүчийн өгүүлбэрийн үйл явц, болц, байдал нь сүүлчийн төгс өгүүлбэрийнхтэй ерөнхийдөө зэрэгцэн болох, зэрэгцүүлэн тоочих утга санаа гаргадаг;

ХАРИН

Холбогдсон хэллэгийн нэг тал нь баталсан, нөгөө тал нь үгүйсгэсэн утгатай байна.

ЭСВЭЛ

Хоёр юм үзэгдлийн аль нэгийг сонгох, эс сонгох, болзол тавих утгатай

БОЛ

Хоёр үйл явдлыг эсрэгцүүлэн жишихэд хэрэглэнэ.

Харилцан зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

- ▶ Нийлмэл өгүүлбэрийн бүрэлдэхүүнд байгаа нэг өгүүлбэрийн хэсэг нь өгүүлэгдэхүүний утга, үүрэг, шинжийг хадгалсан байвал, түүнтэй харилцан зэрэгцэх холбоонд байгаа нөгөө өгүүлбэрийн хэсэг нь заавал өгүүлэхүүн өгүүлбэрийн утга, үүрэг, шинжийг хадгалсан байна:



Харилцан зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

Өгүүлэгдэхүүн өгүүлбэр

- ▶ Үйлийн эзэн, субъектийн утгатай:
- ▶ Өгүүлэхүүн нь нэрийн зүйлээр илэрнэ: ... **норсон байх нь сайхан**;
- ▶ Өгүүлэхүүн нь нэрийн тийн ялгалд байна: **буга намнадаг (Ø) нь манайд**
- ▶ Өгүүлэгдэхүүн нь харь.т.я-д байна: **чиний хэлдэг тун зөв**;

Өгүүлэхүүн өгүүлбэр

- ▶ Бүхэлдээ өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэнэ;
- ▶ Өгүүлэхүүн гишүүн өгүүлбэр нь хоёр бүрэлдэхүүнт байж болно:
- ▶ Гэ- холбох үгээр өгүүлэгдэхүүнтэйгээ холбогдох нь элбэг: **уруу газар ургана гэдэг нь хө улиас модны жам юмаа хө**

УГСАРСАН НИЙЛМЭЛ ӨГҮҮЛБЭР

- ▶ Угсруулах холбоонд суурилсан байна;
- ▶ Дагуул өгүүлбэр + Цөм өгүүлбэр
- ▶ Гишүүн өгүүлбэр : Гол өгүүлбэр

Нэг өгүүлбэр нь голлон захирч, нөгөө өгүүлбэр нь аль нэг гишүүний үүргээр дагалдан захирагдаж, угсруулах холбоогоор холбогдсон нийлмэл өгүүлбэр



Тодотгол гишүүн өгүүлбэр

Өгүүлэхүүн нь

- үйлийн тодотгон холбох нөхцөлтэй үйл үг: ***санасан сэтгэлийн минь үгийг сонсоорой***
- Тэмдэг нэр: ***Үнэн сайтын үг яриа цөөн өвс ус сайтай газар буугаарай***
- Хэрэгтэй, ёстой, мэт, шиг, тухай: ***Чамд хэрэгтэй зүйл энд байна, Бидний байх ёстой газар тэр шүү;***

Өгүүлэгдэхүүн нь

- Харьяалахын тийн ялгалын ил бүтээвэртэй байвал ЯЛГАСАН: ***Миний төрсөн нутаг***
- Харьяалахын тийн ялгалын “тэг” бүтээвэртэй байвал ЭС ЯЛГАСАН: ***Төрсөн нутаг***

Гол өгүүлбэртэй нь

- ГЭ-: [гэ-+тодот.хол.нөх.]: “Би чамд хайртай” гэдэг үгийг тоглоомоор хэлж болдог гэж үү?: гишүүн өгүүлбэр нь оруулбар өгүүлбэрийн шинжтэй байна;
- ГЭ-гүй: [ахын дуртай] хоол нь цуйван, Шар хүн шартай, шарсан мах амттай

Гол өгүүлбэрийнхээ


- Урдүүр: **явсан нохой яс зууна**
Дундүүр: **Эцсийн эцэст, ингэж уулзах өдөр ирдэг байжээ**



Тусагдахуун гишүүн өгүүлбэр

Гол шинж нь

- Угсарсан НӨ-ийн бүрэлдэхүүнд багтаж, гол өгүүлбэрийнхээ өгүүлэхүүнийг үйлэнд өртөх бодит юмын утгаар нэмэн дэлгэрүүлж:
Инээдэгийг эр дагана;
- Гол өгүүлбэртээ угсруулах холбоогоор захирагдсан: ***Байх хүний өгөхийг хүлээ***
- Дагуул өгүүлбэр: ***Байх хүний өгөхийг-Т; хүлээ-
R***



ШУУД БА ШУУД БУС ТУСАГДАХУУН ГИШҮҮН ӨГҮҮЛБЭР

Өгүүлэхүүн нь

- Нэр үг ба нэршсэн үгээр илэрч: ***хүний сайныг ханилан байж мэд, хүлгийн сайныг унан байж мэд***
- Гол өгүүлбэрийн тусах өгүүлэхүүнд заахын тийн ялгалаар захирагдана: ***Инээдэгийг эр дагана;***

Өгүүлэхүүн нь

- Нэр үг ба нэршсэн үгээр илэрч: ***хүний сайныг ханилан байж мэд, хүлгийн сайныг унан байж мэд***
 - Гол өгүүлбэрийнхээ өгүүлэхүүнд эс тусах өгүүлэхүүнд өгөх орших, гарах, үйлдэх, хамтрахын тийн ялгалаар захирагдана: ***бидэнд үргэжл тусалж дэмжиж байдагт тань талархаж явдаг шүү; Идэхээс өөрийг хийхгүй, инээхээс өөр аягггүй..., Би чиний хэлсэнтэй санал нэг байна;***
-

ШУУД БА ШУУД БУС ТУСАГДАХУУН ГИШҮҮН ӨГҮҮЛБЭР

Өгүүлэгдэхүүн нь


- Харьяалахын тийн ялгалаар: ***Чиний инээхэд би дуртай;***
- Заахын тийн ялгалаар: ***чамайг инээхэд би дуртай;***

Тийн ялгалаар;
ГЭ- холбох үйл үгээр гол
өгүүлбэртэйгээ холбогдоно:

- Тийн ялгалаар: ***явахыг, ирсэнд, инээдгээрээ, уулзсантай,***
- ГЭ- холбох үйл үгээр: ***гэсэнд, гэснийг, гэхэд, гэхээр, гэхтэй зэрэг***



Байц гишүүн өгүүлбэр



Угсарсан НӨ-ийнбүрэлдэхүүнд багтана



Төгс өгүүлэхүүнийг шалтгаан, зорилго, дүр,
байдал, орон, цагийн утгаар нэмэн дэлгэрүүлнэ



Байц гишүүн өгүүлбэр нь:



Хэлбэр нь

- А. Харьяалах, заахаас бусад тийн ялгалтай НҮ:
 - ***Өвсөө нартайд хадаж аваарай!***
 - ***Болсноос ам хүр, буурлаас үг сонс***
 - Б. Үйлийн угсруулан холбохын нөхцөлтэй ҮҮ:
 - ***Ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал;***
 - ***Хөшиг нээгдмэгц нууц тайлагдана***
 - ***Өр мянган лан хүрэхэд тайжийн санаа амардаг***
-
- В. Угсруулан хлобох үг, холбох үүрэгтэй туслах үгээр гол өгүүлбэртэйгээ холбогдох нь бий:
 - ***Зүдрэхийн цагт зовлонг хуваалцах Зүрхний хэдэн андууд минь***
 - ***Маргааш учрахын тулд өнөөдөр салдаг;***

БАЙЦ ГИШҮҮН ӨГҮҮЛБЭРИЙН

Өгүүлэгдэхүүн нь

- Заахын тийн ялгалын
- **ИЛ: Ялгасан:** өөрийнхөө унааг ирэхлээр..., манай хичээлийг тарангуут...
ДАЛД: Эс ялгасан: Нэр хугарахаар яс хугар

АНГИЛАЛ

орны

цагийн

дүрийн

шалтгааны

зорилгын

Жишээ нь:

ОРНЫ БАЙЦ ГИШҮҮН
ӨГҮҮЛБЭР



ШАЛТГААНЫ БАЙЦ ГИШҮҮН
ӨГҮҮЛБЭР



ЗОРИЛГЫН БАЙЦ ГИШҮҮН
ӨГҮҮЛБЭР



ЦАГИЙН БАЙЦ ГИШҮҮН
ӨГҮҮЛБЭР



ДҮР БАЙДЛЫН БАЙЦ
ГИШҮҮН ӨГҮҮЛБЭР



Олон гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр

З-ААС ДЭЭШ ТӨВТЭЙ

ХЭД ХЭДЭН ЭНГИЙН ӨГҮҮЛБЭР, ХЭД ХЭДЭН
ХЭЛЗҮЙН АРГА

1

Шугаман дараалалтай, захируулах холбоогоор холбогдсон байна:



2

Сүүлчийн өгүүлбэр нь бусад өгүүлбэрээ захирсан, харьцангуй цөм шинжтэй гол өгүүлбэр байна:

3

Гишүүн өгүүлбэрүүд нь ижил хэлбэрээр гол өгүүлбэртээ холбогдсон байна:

4

Гишүүн өгүүлбэрүүд нь өөр өөр хэлбэрээр гол өгүүлбэртээ холбогдсон байж болно:



Холимог нийлмэл өгүүлбэр

- ▶ Дундын шинжтэй өгүүлбэр юм;
- ▶ Бүтэцдээ 3 буюу түүнээс дээш энгийн өгүүлбэрийг багтаасан байна:
- ▶ Тэдгээр өгүүлбэр нь өөр хоорондоо:


зэрэгцүүлэх

холбоогоор
холбогдсон байна.

угсруулах


Харилцан захируулах

Зэрэгцэх холбоонд байгаа
өгүүлбэр + харилцан захирах
холбоонд байгаа өгүүлбэр




- ▶ Гэтэл морин төвөргөөн сонсогдож, нохой бороолсоор, нэг хүн хүн ирсэн нь ахлах ухуулгч байлаа;

Зэрэгцэх холбоонд байгаа
өгүүлбэр + угсруулах холбоонд
байгаа өгүүлбэр



- ▶ Дамдинг гэртээ ирэхэд айлынхан нь тэднийд цугларчихаад, ач гуч нар нь чихэр боов идэж байв
- 

Харилцан захирах холбоонд
байгаа өгүүлбэр + угсруулах
холбоонд байгаа өгүүлбэр



- ▶ Буюу өгүүлэгдэхүүн+ өгүүлэхүүн гишүүн өгүүлбэртэй угсарсан нийлмэл өгүүлбэр холилдсон хэв маяг.
- ▶ Өвөлдөө малыг заавал усалж байгаарай гэж малчин Товуудай бидэнд сануулсан нь их тус боллоо;



Зэрэгцүүлэх +
харилцан захируулах +
угсруулах



- ▶ Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр+өгүүлэхүүн ба өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэр + угсарсан нийлмэл өгүүлбэр холилдсон хэв маяг
- ▶ Тэр галын гэрэл гармагц Дамдинсүрэн, Магсаржав хоёр нэгэн зэрэг буудсан нь шөнийн чимээгүй нам гүм агаарт түсхийж, монгол цэрэг сүртэй их дуугаар уухай хашгиран дайрав



Хөндлөнгийн оруулбар өгүүлбэртэй нийлмэл өгүүлбэр

Гол өгүүлбэрийн
предикат нь

- Их төлөв тусах үйл үгээр илэрдэг зүй тогтолтой.
- **Ярьж хэлэхийн холбогдолт үйл үгс**
- **Бодож санахын холбогдолт үйл үгс** гэсэн хоёр зүйлд болно:

ЯРИХ, ХЭЛЭХ

АСУУ-	ӨГҮҮЛ-
СОНС-	ДУУЛ-
ЕРӨӨ-	УНШ-
ЗӨВЛӨ-	ТОГЛО-
ИЛТГЭ-	МЭД-
ХЭЛ-	

БОДОХ, САНАХ

БОД-	ҮЗ-
САНА-	ХАР-
МЭД-	ХИЙ-
ОЙЛГО-	МЭДЭР-
СЭТГЭ-	
УХААР-	